Байгууллага нь Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 271 дүгээр тушаалаар Татварын хэлтсийг Татварын газар болгон өөрчилж, Татварын Ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/03 дугаар тушаалаар газрын бүтэц, чиг үүргийг баталсан;
- Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн;
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр баталж, 2024.01.01-ний өдрөөс эхлэн мөрдсөн;
- Сангийн сайдын 2024 оны 2024 оны 229, А/211 дугаар тушаалаар Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, төсвийн эдийн засгийн ангилал, санхүүгийн байдлын тайлангийн дансны жагсаалтыг шинэчлэн баталсан.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьяр хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Татварын Ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/156 дугаар тушаалаар батлагдсан Монголын татварын албаны "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаанд мөрддөг, тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийн дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 97,296.4 мянган төгрөгөөр буюу 4.22 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,030.00	3,590.00	(9,440.00)
Авлага	142.4	652.2	509.8
Бараа материал	76,996.6	76,827.4	(169.2)
Үндсэн хөрөнгө	2,564,989.9	2,580,298.9	15,309.0
Хуримтлагдсан элэгдэл	(351,779.5)	(455,285.5)	(103,506.0)
Нийт хөрөнгө	**2,303,379.4**	**2,206,083.0**	(97,296.4)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,303,379.4	2,206,083.0	(97,296.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**2,303,379.4**	**2,206,083.0**	**(97,296.4)**

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын газрын санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Татварын газрын 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан данс нь мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайланд оны эхэнд Төрийн сан дахь ахмадын сангийн данс 13,030.0 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан, тайланд онд ахмадуудын баярын үйл ажиллагаа, амралтын зардал, эмчилгээний зардалд нийт 9,440.0 мянган төгрөгийг зарцуулснаар мөнгөн хөрөнгийн үлдэгдэл энэ хэмжээгээр буурч, оны эцэст 3,590.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 15,309.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 2,580,298.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон нь тайлант онд ТӨБЗГ-ын даргын 2024 оны А-1/2405 албан бичгээр 4,329.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, А-

ТӨРИЙН АУДИТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

1/1772 албан бичгээр 10,770.0 мянган төгрөгийн 3 ширхэг суурин компьютер орлогод бүртгэсэн, 210.0 мянган төгрөгийн газрыг үнэлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 97,948.7 мянган төгрөгөөр хасагдан, 2,205,430.8 мянган төгрөг болсон байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төслийг 2,517,934.2 мянган төгрөгөөр баталж, Татварын Ерөнхий газарт хүргүүлсэн байна.

Татварын Ерөнхий газар хүргүүлсэн төсвийн төслийг 605,866.6 мянган төгрөгөөр бууруулан 1,912,067.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Оны эхэнд баталсан төсвийг 520,195.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2,432,263.3 мянган төгрөгөөр баталж, тайлант онд баталсан санхүүжилтийг улсын төсвөөс бүрэн олгожээ.

Тайлант онд тус байгууллага төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70205 (Татвар хураалт, орлого бүрдүүлэлт) хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс олгосон санхүүжилтийн 99.9 хувь буюу 2,429,802.1 мянган төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулж, зардлын хэмнэлтийн 2,461.2 мянган төгрөгийг оны улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
70205	Татвар хураалт, орлого бүрдүүлэлт	2,163,375.60	2,161,017.10	2,358.50	99.89
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,163,375.60	2,161,017.10	2,358.50	99.89
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,500.00	1,418.00	82.00	94.53
80205	Харуул хамгаалалтын зардал	43,200.00	43,179.33	20.67	99.95
80205	Ажил олгогчоос олгох тэтгэмж	173,415.70	173,415.70	-	100.0
80205	Холбооны суваг ашигласны хөлс	50,772.00	50,772.00	-	100.0
	ДҮН	2,432,263.30	2,429,802.13	2,461.17	99.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын газрын төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд ахмадын сангийн дансны эхний үлдэгдэл 13,030.0 мянган төгрөг байсан, тайлант онд орон нутгийн нэмэгдэлд орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн 38,694.5 мянга,

хяналт шинжилгээ үнэлгээний дүнгийн шагналын 3,000.0 мянга, жендерийн мэдрэмжтэй байгууллагын шагналын 600.0 мянга, нийт 42,294.5 мянган төгрөгийн орлого орсон байна.

Орон нутгийн нэмэгдэлд орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтээс гүйцэтгэлээр 37,806.2 мянган төгрөгийг олгож, хэмнэлтийн 888.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, шагналын 3,600.0 мянган төгрөгийг Татварын хэлтсийн үйлдвэрчний эвлэлийн хорооны дансанд шилжүүлж, оны эцэст 3,590.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Татварын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх тухай 29 дүгээр албан бичгийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт, материалын хамт ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн 2,432,263.3 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 12,161.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 7,296.8 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баянхонгор аймгийн Татварын газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллага түүвэрт хамрагдсан бөгөөд аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчилд 77,423.9 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, шалгагдагч байгууллага шийдвэрийн хэрэгжилтийг FAS системд мэдээлсэн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	77,423.9	1	77,423.9	100
Нийт дүн	**1**	**77,423.9**	**1**	**77,423.9**	**100**

Эх сурвалж: Татварын газрын 2024.02.27-ны өдрийн 74 дүгээр албан бичиг

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянхонгор аймгийн Татварын газарт хийх дараагийн аудитаар дараах асуудлыг анхаарах шаардлагатай байна. Үүнд:

1. Татварын Ерөнхий газраас сар бүр улс, орон нутгийн төсвийн сарын төлөвлөгөө, гүйцэтгэл үр дүнгийн шагналыг сар бүр 50 хүртэл хувиар албан хаагчдад олгож байхад 2024 оны жилийн эцэст холбогдох тушаалуудаар байгууллагын нийт албан хаагчдад 88,301.1 мянган төгрөгийн нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулыг давхардуулан цалингийн зардлын хэмнэлт болон ТЕГ-аас оны эцэст тус зардалд хуваарилсан санхүүжилтээс олгосон асуудлыг анхаарах.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨЕРЧЛӨЛТ САНАЛ ДҮГНЭЛТ

2. Татварын газрын санхүүгийн тайланд аудит хийхэд дараах хүндрэлтэй тул санхүүгийн тайлан бэлтгэж байгаа санхүүгийн программад хөгжүүлэлт хийлгэх, ТЕГ-ын баталсан НББББББ-т нийцүүлж өөрчлөх нь зүйтэй байна.

- Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлээр түлш шатахуун тослох материалын эхний болон эцсийн үлдэгдэл 12,485.25 төгрөг гарсан байхад санхүүгийн байдлын тайланд түлш шатахуун тослох материалын эхний болон эцсийн үлдэгдэл 534.14 төгрөг болж зөрүүтэй гарсан;
- Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл дээр тушаалын бланк хасах 30.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй;
- Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг сар бүр тооцоогүй, 12 дугаар сард нэг удаа тооцсон байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 183,381.5 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

1. Нягтлан бодогч нягтлан бодох бүртгэлд зардлыг өглөгийн дансаар дамжуулаагүй 182,729.3 мянган төгрөгийг шууд зардлаар тайлагнасан нь Ангилал, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй тул шууд зардлаар тайлагнасан ажил гүйлгээг өглөгийн дансаар залруулсан.
2. Байгууллагын нягтлан бодогч хүүхэд асрах болон жирэмсэн амаржсаны чөлөөтэй байгаа албан хаагчдын даатгуулагчийн төрлийг буруу мэдээлснээс нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 652.2 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн атлаа санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй нь Иж бүрэн байх, Тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй тул авлагыг нэмэгдүүлэн залруулга хийсэн.

Аудитаар нийт 95,266.2 мянган төгрөгийн 5 зөрчил[1] илэрснээс 88,301.1 мянган төгрөгийн 1 зөрчлийг материаллаг бусаар, 6,965.1 мянган төгрөгийн 4 зөрчлийг материаллаг алдаагаар тооцсон ба материаллаг зөрчлөөр нийт дүн нь аудитаар бидний урьдчилан тогтоосон материаллаг дүнгээс бага тул "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт өгсөн ба аудитаар илэрсэн 687.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 6,277.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, 88,301.1 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмжийг хүргүүллээ.

5.1. Төлбөрийн акт

1. Байгууллагын даргын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар шилдэг татварын улсын байцаагчаар 5 албан хаагчийг шалгаруулж, тус бүр 100.0 мянган төгрөгийг олгохдоо хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно: цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна: ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс,

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

CD5 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Суутган тооцоогүй хувь хүний орлогын албан татварыг байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд татварын улсын байцаагч Д.Даваасамбад 2024 оны 8 дугаар сард 637.7 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.1 дэх "Ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад хэлбэрээр тооцно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчид илүү олгосон цалинг байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.2. Албан шаардлага

1. Баянхонгор аймгийн Татварын газрын харьяалалтай 10 ахмад настнуудыг Архангай аймгийн "Хангай ресорт" амралтын газарт амраах амралтын төлбөрт 5,000.0 мянган төгрөгийг 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр "ЖДЛ" ХХК-д шилжүүлсэн байхад холбогдох анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна: хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.4 дэх "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын харьяалалтай 10 ахмад настнуудыг амраасныг нотлох анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргах албан шаардлагыг хүргүүлэв.

2. Хүний нөөцийн менежер, татварын улсын байцаагч М.Оюунбатыг байгууллагын даргын 2023 оны Б/23 дугаар тушаалаар нууц хамгаалах ажилтнаар томилж, албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тооцож нэмэгдэл олгохоор

заасан байхад 2024 онд 30 хувиар тооцож нэмэгдэл олгосноос, тус албан хаагчид 1,277.4 мянган төгрөгийн нэмэгдлийг илүү олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор батлсан "Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 4.1.8-т "Нууц хамгаалах ажилтнаар томилох тухай шийдвэрт тогтоосон журмын дагуу олгох цалингийн нэмэгдлийг тусгасан байна" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчид холбогдох хууль, тогтоомжийн дагуу нэмэгдлийг зөв тооцож олгон зөрчлийг арилгах

5.3. Зөвлөмж

ТЕГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/266 дугаар тушаалаар байгууллагын даргад 3,195.8 мянга, Баянхонгор аймгийн Татварын газрын даргын мөн өдрийн А/62 дугаар тушаалаар байгууллагын 42 албан хаагчдад 85,105.3 мянга, нийт 88,301.1 мянган төгрөгийн нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 45 дугаар зүйлийн 45.2 дахь "Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ыг зөрчсөн байна.

Зөвлөмж: Төсвийн тухай хууль, тогтоомжийн дагуу төсөвт буцаан төвлөрүүлж байх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу ирүүлж, аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд бүрэн биелүүлж, хэрэгжилтийг нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогчид талархал илэрхийлье.

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ОСРЧЛЭЛТГҮЙ
СЛМАЛ ДУТМЭЛТ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодогч нягтлан бодох бүртгэлд зардлыг өглөгийн дансаар дамжуулаагүй шууд зардлаар тайлагнасан байна.	1	182,729.3			1	182,729.3	1	182,729.3				
Байгууллагын нягтлан бодогч хүүхэд асрах болон жирэмсэн амаржсаны чөлөөтэй байгаа албан хаагчдын даатгуулагчийн төрлийг буруу мэдээлснээс нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг илүү шилжүүлсэн атлаа санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.	1	652.2	1	652.2			1	652.2				
ДҮН	2	183,381.5	1	652.2	1	182,729.3	2	183,381.5	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын даргын 2024.12.20-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар 5 албан хаагчийг шилдэг татварын улсын байцаагчийг тус бүрийг 100.0 мянган төгрөгөөр шагнаж, шагналыг олгохдоо хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй байна.	1	50.0	1	50.0								

Тайлант онд татварын улсын байцаагч Д.Даваасамбад 2024 оны 8 дугаар сард 637.7 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.	1	637.7	1	637.7								
Хүний нөөцийн менежер, татварын улсын байцаагч М.Оюунбатад нууц хамгаалах ажилтны нэмэгдэлд тайлант онд 1,277.4 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	1,277.4			1	1,277.4						
ТЕГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/266 дугаар тушаалаар байгууллагын даргад 3,195.8 мянга, Баянхонгор аймгийн Татварын газрын даргын мөн өдрийн А/62 дугаар тушаалаар байгууллагын 42 албан хаагчдад 85,105.3 мянга, нийт 88,301.1 мянган төгрөгийн нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулллыг цалингийн зардлын хэмнэлт болон ТЕГ-аас оны эцэст тус зардалд хуваарилсан санхүүжилтээс олгосон байна.	1	88,301.1					1	88,301.1				
Баянхонгор аймгийн Татварын газрын харьяалалтай 10 ахмад настнуудыг Архангай аймгийн "Хангай ресорт" амралтын газарт амраах амралтын төлбөрт 5,000.0 мянган төгрөгийг 2024 оны 09 дүгээр сарын 11-ний	1	5,000.0			1	5,000.0						

өдөр "ЖДЛ" ХХК-д шилжүүлсэн байхад холбогдох анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй байна.												
Дүн	5	95,266.2	2	687.7	2	6,277.4	1	88,301.1	0	0	0	0

---oOo---

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ